

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ НЬ ҮНДСЭН ЗАРЧИМД БҮРЭН НИЙЦЭЖ БАЙГААГ БУЮУ ХАРШЛААГҮЙГ НОТОЛСОН ТАЙЛБАР**

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /цаашид "төсөл" гэх/ нь Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлал, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааны үндсэн зарчимд бүрэн нийцэж байгааг дараах үндэслэлээр нотлон тайлбарлаж байна.

### **1.Үндсэн хуулийг дээдлэн сахих, түүний тогтвортой байдлыг хамгаалах зарчмын хүрээнд:**

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл нь Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд бүрнээ нийцсэн болно. Монгол Улсын Үндсэн хуульд төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван салаанд хуваарилсан үндсэн бүтцийг энэ төсөлд өөрчлөхөөр тусгаагүй. Бүгд найрамдах улсын хэлбэр, парламентын засаглал, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал, хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх ёс зэргийг өөрчлөөгүй буюу Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд уг төсөл харшлаагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулж үл болох заалтуудыг хөндөөгүй буюу Монгол Улсын Үндсэн хуулийн Нэг, Хоёр, Гурав, Дөрөвдүгээр зүйл, Тавдугаар зүйлийн 1-3 дахь хэсэг, Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аравдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван дөрөв, Арван тав, Арван ес, Хорин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дөчин долдугаар зүйл, Дөчин есдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Жаран найм, Жаран есдүгээр зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулаагүй.

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулах, санаачлах үйл ажиллагааны журам нь Үндсэн хуулийн Жаран найм, Жаран есдүгээр зүйлд бүрнээ нийцсэн болно. Мөн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болох нөхцөл үүсээгүй. Тодруулбал, төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт "Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсон тохиолдолд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно," мөн зүйлийн 3.2 дахь хэсэгт "Үндсэн хуулийн Жаран есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын Их Хурал /цаашид "Улсын Их Хурал" гэх / ээлжит сонгууль явуулахын өмнөх зургаан сарын дотор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно" гэж заасантай тус тус харшлаагүй.

Монгол Улсын Засгийн газар бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хууль хэлбэрээр санаачилж байна. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл Үндсэн хуулийн нийт зүйлийн 1.4 хувийг хөндөж байгаа нь Үндсэн хуулийг бүхэлд нь өөрчлөх буюу хянан үзэхэд

хамаарахгүй болно. Уг төслөөр Үндсэн хуулийн нэг зүйлийн холбогдох хэсгийг өөрчлөн найруулж байна.

## **2. Ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах зарчмын хүрээнд:**

Үндсэн хуульд өөрчлөлт оруулахаар төсөл боловсруулах бүхий л үйл ажиллагаанд иргэд, улс төрийн нам, олон нийтийн бусад байгууллагын оролцоог хангаж ажилласан. Тодруулбал, 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр улс төрийн 21 нам Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг гаргасан бөгөөд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн хамрах хүрээнд “сонгуулийн холимог систем бүхий... олон намын оролцоотой зөвшилцлийн ардчилалд шилжих,” “сонгогчдыг төлөөлөх мандатын тоог нэмж, Улсын Их Хурлын нэг гишүүний нөлөөллийн эрх мэдлийг багасгах” зэрэг агуулгыг дэмжиж, тунхаг бичиг гаргасан.

Монгол Улсын Их Хурал 2022 оны 34 дүгээр тогтоолоороо “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлаар ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах зорилгоор олон нийтийн саналыг судлах сэдвийн хүрээ”-г тодорхойлж, сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэх, сонгогчдыг төлөөлөх мандатын тоог нэмэгдүүлэх асуудлыг тусгасан.

Монгол Улсын Их Хурал 2022 оны 54 дүгээр тогтоолоороо “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 01, 02 дугаар тогтоол гарсантай холбогдуулан хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн харилцан хяналт-тэнцлийг хангах хүрээнд төрийн эрх барих дээд байгууллагад ард түмнийг төлөөлөх Улсын Их Хурлын гишүүдийн тоог шинэчлэн тодорхойлох, Улсын Их Хурлын сонгуулийн дэвшилтэт тогтолцооны зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулах асуудлыг судлан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”-ийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Улсын Их Хурлын 2022 оны 80 дугаар тогтоолоор улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатайгаар тодорхойлох, асуудлын эрэмбэ, шийдвэрлэх арга зам, гаргах шийдвэрийн талаар иргэдтэй зөвлөлдөх, үндэсний зөвшилцлийг хангах зорилгоор “Зөвлөлдөж шийдье” сэдэвт зөвлөлдөх санал асуулга зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Зөвлөлдөх санал асуулгын дүнг үндэслэн гаргасан зөвлөмжид иргэдийг төлөөлөх парламентын чадавхыг нэмэгдүүлж, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх талаар, Улсын Их Хурлын сонгуулийг явуулахдаа олонхын болон хувь тэнцүүлсэн тогтолцоог хослуулах нь зүйтэй талаар тус тус дэмжсэн дүн гарсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын баталсан хуваарийн дагуу 2023 оны 04 дүгээр сарын 19-25-ны өдрүүдэд 21 аймагт 22 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Эдгээр хэлэлцүүлгийг нээлттэй зохион байгуулж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг сурталчлан таниулж, оролцсон иргэдэд төслийн товч тайлбарыг бичгээр тарааж, амаар танилцуулсан бөгөөд төсөлтэй холбогдуулан иргэдийн саналыг санал асуулгын хуудсаар авсан. Эдгээр хэлэлцүүлэгт 6000 орчим иргэн биечлэн оролцож, 4800 орчим саналын хуудсаар давхардсан тоогоор 33,900 гаруй санал өгч, төслийн заалт бүрд 0-5 оноо өгч саналаа илэрхийлсэн болно.

2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийг зохион байгуулагдаж, хэлэлцүүлэгт Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг дэлгэрэнгүй танилцуулж, улс төрийн 36 намын удирдлага, иргэний нийгэм болон судлаачдын саналыг сонссон.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шүүхийн ерөнхий зөвлөл, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын ерөнхий прокурор холбогдох яамд зэрэг хуульд тусгайлан заасан болон бусад байгууллагуудад албан бичгээр хандаж санал авсан. Мөн Улсын дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн намуудаас санал авахаар төслөө хүргүүлсний дагуу 13 улс төрийн намаас төслийг бүрэн болон зарчмын хувьд дэмжсэн санал ирсэн байна. Түүнчлэн, Үндсэн хуулийн эрх зүй болон улс төр судлалаар мэргэшсэн судлаачид, эрдэмтдийн саналыг хүлээн авч, төсөлд зохих өөрчлөлт хийсэн.

2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдрөөс хойш Монгол Улсын Засгийн газрын <https://mongolia.gov.mn>, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын <https://cabinet.gov.mn>, Улсын Их Хурлын Тамгын газрын <https://d.parliament.mn> цахим хуудсанд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг байршуулж, төслийн санал авах ажлыг зохион байгуулав.

### **3. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагаа бодитой, ил тод байх зармыг хангах хүрээнд:**

2000 он болон 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, 2011, 2012, 2015 онуудад хийгдсэн шүүмж, хэлэлцүүлгүүд, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбогдох судалгаа, дүн шинжилгээ, Улсын Их Хурлын 2022 оны 34, 54 дүгээр тогтоол, 2023 оны “Зөвлөлдөж шийдье” санал асуулгын зөвлөмж, хэлэлцүүлгийн дүн, эрдэмтэн судлаачдын саналд тулгуурлан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг өргөн мэдүүлж байгаа нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилга, үйл ажиллагаа дур зоргын бус, Үндсэн хуульд оруулах өөрчлөлт нь улс төрийн аль нэгэн нам, бүлэг, давхаргын ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалаагүй болохыг нотолж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл нь Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний үндсэн эрх, эрх чөлөөг дордуулаагүй, төрийн эрх мэдлийг хуваарилсан зарчмыг үгүйсгээгүй болно. Ард түмнийг төлөөлөх парламентын чадавхыг сайжруулах, хууль тогтоомж болон хуулийн биелэлтэд тавих хяналтыг чанаржуулах замаар Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын баталгаа болсон парламентын засаглалыг төгөлдөржүүлэх; Монгол Улсын Үндсэн хуульд сонгуулийн холимог тогтолцоог тодорхой зааж баталгаажуулснаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо тогтвортой байх, намууд сонгуульд шударгаар өрсөлдөх, иргэдэд ойлгомжтой байх, гадаадад байгаа иргэний сонгох эрхийг баталгаажуулах үүднээс Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулсан.

Төслийг боловсруулах, санаачлахад хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж байх; төслийн талаарх иргэдийн болон тэдгээрийн хамт олон, байгууллагын саналыг олон нийттэй харилцах бүх сувгаар хүлээн авах талаар анхааран ажиллав.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд заасан зарчмуудыг бүрэн хангасан гэж үзэж байна.

## ХУУЛЬ САНААЧЛАГЧ